



УВС АЙМГИЙН ИТХ-ЫН 6 ДАХЬ УДААГИЙН СОНГУУЛИЙН IX ХУРАЛДААН БОЛЛОО



Увс аймгийн ИТХ-ын 6-дахь удаагийн сонгуулийн IX хуралдаан 2015 оны 03 сарын 30-ны өдөр "Иргэдийн оролцоо" хуралдааны танхимд боллоо. Хуралдаанаар: 1. 2015 оны төсвийн тодотголын тухай; /Аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэн, ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга

- 4. Энхбаяр/
- 2. "Их Наяд – Увс 2024" хөтөлбөр батлах тухай; /Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Ганболд/
- 3. Зарим газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай мэдээлэл: /Аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга З.Ганболд/ гэсэн 3 асуудал хэлэлцэж 5 тогтоол баталлаа.

АЙМГИЙН ИТХ-ЫН ТЭРГҮҮЛЭГЧИЙН ХУРАЛ БОЛЛОО.

Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурал 03 сарын 24, 26-ны өдрүүдэд боллоо.

Хурлаар:

- 1. Мэргэжлийн боловсрол сургалтыг хөгжүүлэх, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх хөтөлбөр
- 2. Хийжүүлсэн ундаа, чихрийн хэрэглээг багасгах хөтөлбөрийн тухай
- 3. Их наяд хөтөлбөрийн тухай
- 4. Төсвийн тодотголын тухай
- 5. Татварын орлогын бүрдүүлэлтийн тухай Татварын хэлтсийн даргын мэдээлэл
- 6. Орон нутгийн өмчийн нэгтгэлийн дүн мэдээ, бүртгэлийн талаар авах арга хэмжээний тухай
- 7. "Мини зах"ын менежментийн гэрээний үүргийн биелэлтийн талаар ажлын хэсгийн тайланг хэлэлцэх
- 8. Орон нутгийн өмчийг хувьчлах тухай
- 9. Гулзат орон нутгийн хамгаалалттай газрын менежментийн төлөвлөгөө, Агнуурын бүсийн менежментийн төлөвлөгөө, Стратеги төлөвлөгөө хэлэлцэх
- 10. Нэрэмжит болгох тухай "Завхан сумын соёлын төвийг МУГЖ Жанчивийн нэрэмжит болгох
- 11. 6-р цэцэрлэгийн ой тэмдэглэх тухай
- 12. Шагналд тодорхойлох тухай гэсэн асуудлуудыг авч хэлэлцлээ.



СУМДЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРЫН СУРГАЛТ АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ

Увс аймгийн ИТХ-ын ажлын төлөвлөгөөний дагуу Сумдын ИТХ-ын Нарийн бичгийн дарга нарын сургалт 3 дугаар сарын 13, 14-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Уг сургалтын гол зорилго нь сумдын ИТХ-ын Нарийн бичгийн дарга нарт НӨУБ-ын 2014 оны ажлын үр дүн, 2015 онд хэрэгжүүлэх зорилтууд, асуудлуудын талаар танилцуулах, тэднийг нэгдсэн ойлголт, чиглэлтэй болгох, хурлын дотоод ажил, цаг үеийн ажлаар зөвлөмж, үүрэг чиглэл өгөхөд оршино.



Сургалтаар Өндөрхангай, Наранбулаг, Өмнөговь сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нар өөрсдийн ажлын сайн туршлагаа бусад сумдын НБД-нарт танилцуулж санал бодлоо солилцлоо.

УСНЫ БОЛОВСРОЛ ОЛГОХ УСНЫ МЭДЭЭЛЛИЙН ТӨВ НЭЭГДЛЭЭ.



Дэлхийн усны өдрийг тохиолдуулан Увс аймгийн Чандмань Увс ХХИ байгууллага дээрээ иргэдэд усны боловсрол олгох усны мэдээллийн төвийг нээлээ. Төвийн нээлтэнд Аймгийн ИТХ-ын дарга Ч.Чимэд, "Чандмань увс" ХХК-ний ТУЗ-ийн дарга Ч.Баттулга, компаний удирдлагууд оролцож тууз хайчлан шагнал гардууллаа. Төв сэдэвтэй шүлэг бичих, гар зургийн уралдаан зарласнаа дүгнэж идэвхтэй оролцсон оюутан, сурагчдыг шагналаа. Нээлтэнд 2 дугаар цэцэрлэгийн бяцхан сурагч оролцож усны талаарх сургамжит үзүүлбэр үзүүлээ.

нээж байгаатай холбогдуулан оюутан сурагчдын дунд "Ус" сэдэвтэй шүлэг бичих, гар зургийн уралдаан зарласнаа дүгнэж идэвхтэй оролцсон оюутан, сурагчдыг шагналаа. Нээлтэнд 2 дугаар цэцэрлэгийн бяцхан сурагч оролцож усны талаарх сургамжит үзүүлбэр үзүүлээ.

УИХ-ЫН ГИШҮҮН Б.ЧОЙЖИЛСҮРЭН АЙМГИЙН ИТХ-ЫН ТӨЛӨӨЛӨГЧИДТЭЙ УУЛЗЛАА



Аймгийн ИТХ-ийн 8-р хуралдааны үеэр төлөөлөгч С.Амраа, Б.Цэцээ, М.Ганбаатар нар Увс аймгаас УИХ-д сонгогдсон гишүүдтэй уулзаж аймаг орон нутгийн хөгжлийн асуудлаар санал бодлоо солилцож, хамтран ажиллаж байх хэрэгтэй байна гэсэн санал гаргасны дагуу УИХ-ын гишүүн Б.Чойжилсүрэн Увс аймагт ажиллах үеэр ИТХ-ын ажлын алба, нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хорооны дарга Цэдэнбал нар хүсэлт тавьж аймгийн ИТХ-ын төлөөлөгчидтэй уулзах уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд аймгийн ИТХ-ийн төлөөлөгч, аймгийн засаг даргын орлогч Б.Цэцээ, ЗДТГ-ын хэлтэс, тасгийн дарга нар, ИТХ-ын ажлын албаныхан нийт 24 хүн оролцлоо.

ХУРАЛ.МН САЙТЫН 2 ДУГААР ЭЭЛЖИЙН СУРГАЛТ БОЛЛОО.

Монгол улсын 21 аймаг, 330 сум, нийслэлийн 9 дүүргийн ИТХ-ын нэгдсэн портал сайт Хурал. Мн сайтын админуудын 2 дугаар ээлжийн сургалт УБ хотноо эхэллээ. Энэ удаагийн сургалтаар khural.mn-ий агуулга, нийтлэлийн стандарт, мэдээ бэлтгэх, цахим хуудас хөтлөх арга зүй зэрэг агуулгыг суралцах юм. Админууд сургалтанд оролцоноор

- Khural.mn-ий стандартыг суралцаж, баримтлах, сумдын админуудад зааж сургах, хэрэгжилтэд нь хяналт тавих
- Идэвхтэй хөгжихгүй байгаа сумдын дэд цахим хуудсыг хөгжүүлэхэд анхаарах, дахин сургалт зохион



байгуулах 2016 оны орон нутгийн сонгуульд khural.mn-ий стандартыг баримталж улс төржилтөөс ангид байгаа баталж төсөлтэй гэрээ байгуулах аж.



ОНЦЛОХ МЭДЭЭ

3 САР

ГАМШГИЙН АЮУЛЫН ЗАРЛАН МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР БЭЛЭН ЖАГСЛАА

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор баталсан "Гамшгийн аюулын



тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд гамшгийн аюулын зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуулилтанд идэвхитэй оролцлоо. Гамшгийн дуут дохио дуугарснаар Цэдэнбалын талбайд албан байгууллагууд бэлэн байдалд жагслаа. 30 гаруй байгууллагын 1000-аад албан хаагч жагсаалд оролцож байна. Жил бүрийн 03 дугаар сарын 4 дэх долоо хоногт улс орон даяар зарлан мэдээллийн техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах, түүнд хамрагдаж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог дээшлүүлэх зорилгоор Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг хийдэг. "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам"-ыг хэрэгжүүлэх хүрээнд гурав дах жилдээ уламжлал болгон зохион байгуулж байна.



УЛААНГОМ СУМ:

Аймаг, орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө өөрийн мэдлэг чадвар, нөөц бололцоогоо дайчлан ажиллаж оюунаа чилээж буй аймгийн ИТХ-ын эмэгтэй төлөөлөгчдөө олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийн баярын мэндийг ажлын албаны зүгээс хүргэж гарын бэлэг гардууллаа.



Аймгийн УЗХ-той хамтран 2015 оны 03 дугаар сарын 23-ны өдөр багийн ИНХ-ын дарга, Засаг дарга, нийгмийн ажилтан нарыг оролцуулсан сургалтыг "Иргэний танхим"-д, 03 дугаар сарын 24-ний өдөр сумын харъяа төсөвт байгууллагын дарга, эрхлэгч нар, УЗХ-ны идэвхитэй, дэмжигч /

ХХЦГ, Сургууль, Цэцэрлэг, ӨЭТөв, Соёлын төв/ нарын төлөөллийг оролцуулсан сургалтыг "Иргэний танхим"-

д, 03 дугаар сарын 25-ны өдөр сумын ИТХ-ын төлөөлөгчдийг оролцуулсан сургалтыг Аймгийн УЗХ-ны байранд хийлээ.

Дээрхи сургалтуудыг Улаан Загалмайн дунд шатны хороотой хамтарсан төлөвлөгөө гарган зохион явууллаа. Сургалтын үр дүнд Анхан шатны хорооны үйл ажиллагаа эрчимжих, харъяа байгууллага, сумын ИТХ-ын төлөөлөгчид санаачлагатайгаар хамтран ажиллах нөхцөл бүрдэх юм.

САГИЛ СУМ:

Хилийн малын хулгайгаас урьдчилан сэргийлэх, хил дамнасан малын хулгайтай хэрхэн тэмцэх тухай ухуулга сурталчилгааг аймгийн хилийн цэргийн тагнуулын алба, цагдаагийн хэлтэс, 1,2 дугаар багийн Засаг дарга Н.Баянмөнх, Д.Түнэрэв, ИТХ-ын нарийн бичгийн дарга



Г.Пүрэвсүрэн нар Баянзүрх, Боршоо багийн хилийн дагуух 30 гаруй айлуудад хийв.

УВСЫН ОЮУТНУУД ТАЙВАНИЙН ЖУНХУА ИХ СУРГУУЛЬД СУРАЛЦАХ БОЛОМЖ НЭЭГДЛЭЭ

Увс аймаг БНХАУ-ын Тайвантай олон талаар



хамтран ажиллаж байгаа. Увс аймаг, Тайванийн хамтын ажиллагааны хүрээнд Увсын брэнд чацарганыг дэлхийн зах зээлд гаргах боломж бүрдсэн. Харин

одоо Тайван улсад дэлхийн боловсролыг эзэмших боломж Увсын оюутан залуусын өмнө нээгдэж байна. БНХАУ-ын Тайванийн "Тайван Монголын боловсрол, эрүүл мэнд, бизнесийг дэмжих нийгэмлэг"-ийн дэд зөвлөлийн дарга Хун Хоу Мин, Тайванийн Жунхуа их сургуулийн Олон нийттэй харилцах албаны дарга профессор Сиэ Хун Ниан нар Увс аймагт ажиллаж, Увс аймгийн оюутнуудыг Тайван улсад суралцуулах талаар Увс нутгийн хөгжлийн хөтөч ТББайгууллага, Жунхуа их сургуультай гэрээ байгууллаа. Ийнхүү хамтын ажиллагааны гэрээ байгуулснаар ээлжит хичээлийн жилд 80 дээш хувийн үнэлгээтэй суралцаж чадвал тэтгэлэгт хамрагдах боломж бүрдэж байгаа юм. Тайванийн Жунхуа их сургуульд манай аймгийн 50 хүртэл оюутан инженер, технологийн чиглэлээр суралцана.



Хаяг

Увс аймаг, Улаангом хот, 3-р баг Ө.Бадрахын гудамж, ЗДТГ-ын байр 210гоот Утас :70453627

Утас :70452517

Утас :70452828

Факс :70452214

И Мэйл:

info@khural.uv.gov.mn

Вэб сайт:
uv.khural.mn

Facebook:
www.facebook.com/groups/uv.s.ith